

2008.10.22

Дугаар 221

“Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер,  
Дилерийн компанийн харилцагчдыг шилжүүлэх  
тухай журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер, дилерийн компанийн харилцагчдыг шилжүүлэх тухай журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Брокер, дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон компаниудын харилцагчдыг шилжүүлэх үйл ажиллагааг 2008 оны 4 дүгээр улиралд багтаан шийдвэрлэж, Хороонд танилцуулахыг Ажлын алба /О.Ганбат/-нд үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Х.Бум-Эрдэнэ/-т, олон нийтэд сурталчлахыг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Хуулбар үнэн:  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

О.ГАНБАТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ НЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОН  
БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИЙН ХАРИЛЦАГЧДЫГ  
ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон брокер, дилерийн компанийн /цаашид “компани” гэх/ харилцагчдыг холбогдох баримт бичиг, электрон мэдээллийн хамт брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй /цаашид “эрх бүхий компани” гэх/ бусад компанид шилжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

**Хоёр. Харилцагчдыг шилжүүлэх комисс**

2.1. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон компанийн харилцагчдыг уралдаант шалгаруулалтын үндсэн дээр эрх бүхий компанид шилжүүлнэ.

2.2. Уралдаант шалгаруулалтыг Хорооны даргын томилсон 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс зохион байгуулах бөгөөд комисс нь Хорооноос 3, “Монголын хөрөнгийн “Монголын хөрөнгийн бирж” ХК” ХК /цаашид ““Монголын хөрөнгийн бирж” ХК” гэх/, “ҮЦТТХТ” ХХК-иас тус бүр 1 мэргэжилтнээс бүрдэнэ.

2.3. Комисс уралдаант шалгаруулалтыг зохион байгуулахдаа Иргэний хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ Журмыг удирдлага болгоно.

2.4. Уралдаант шалгаруулалтад оролцох сонирхолтой эрх бүхий компанийг шаардлагатай мэдээллээр хангах үүргийг комисс хүлээнэ.

2.5. Комиссын гишүүд эрх бүхий компаниудаас ирүүлсэн уралдаант шалгаруулалтын материалтай танилцаж, гишүүн тус бүр энэ журмын 3.2, 3.3.-т заасан заалт тус бүрээр 3 хүртэл оноо өгч дүгнэнэ.

2.6. Комиссын гишүүдээс өгсөн онооны нийлбэрээр эцсийн дүнг гаргаж шалгарсан эрх

бүхий компанид харилцагчдыг шилжүүлэх, тухайн аймагт салбар байгуулахыг зөвшөөрөх тухай шийдвэрийг Хорооны дарга гаргана.

2.7. Энэ журмын 2.6-д заасан Хорооны шийдвэр гарсны дараа шалгарсан компани тухайн аймагт ажиллах салбар байгуулан Улсын бүртгэлийн албанд бүртгүүлж энэ тухайгаа Хороонд мэдэгдэнэ.

2.8. “Монголын хөрөнгийн бирж” ХК, “ҮЦГТТХТ” ХХК нь тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон компанийн үйл ажиллагаа явуулж байсан хугацааны хэлцлийн жагсаалт, харилцагчдын талаарх мэдээлэл, харилцагчийн данснаас гарсан мөнгөний жагсаалтыг электрон хэлбэрээр шалгарсан эрх бүхий компанид хүлээлгэн өгнө.

2.9. Комисс уралдаант шалгаруулалтад ирүүлсэн материалиудыг уралдаант шалгаруулалтын материал хүлээж авах сүүлчийн хугацаанаас хойш ажлын 15 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд уг хугацааг ажлын 10 хүртэл хоногоор сунгаж болно.

### **Гурав. Уралдаант шалгаруулалтад ороцогчид тавигдах шаардлага**

3.1. Уралдаант шалгаруулалтад Хорооноос үнэт цаасны зах зээл дээр брокер дилерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани оролцох бөгөөд тэр нь Хорооны 2006 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээл дээр мэргэжлийн үйл ажиллагаа явуулах журам”-д заасан шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

- 3.1.1. үйл ажиллагаагаа сүүлийн 1 жилийн хугацаанд тогтмол явуулсан байх;
- 3.1.2. шилжүүлж авсан харилцагчдад үйлчлэх салбар нээн ажиллуулах санхүүгийн болон хүний нөөцийн боломжтой байх;
- 3.1.3. Хороонд төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлс, “Монголын хөрөнгийн бирж” ХКийн гишүүний болон суудлын хураамж, арилжааны шимтгэл, төлбөр тооцоо хадгаламжийн байгууллагад төлөх төлбөр зэргийг хугацаанд нь бүрэн төлсөн байх;
- 3.1.4. Үнэт цаасны төлбөр тооцоо болон харилцагчдын хувьцааг өмчлөгчийн зөвшөөрөлгүй зарах зэрэг хууль бус үйлдэл гаргаж байгаагүй байх;
- 3.1.5. Тухайн жилд компани болон албан тушаалтан Хорооноос захиргааны шийтгэл хүлээгээгүй байх;

- 3.1.6. Үнэт цаасны зах зээлийн тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, Хорооноос баталсан журам, зааврыг биелүүлж ажилладаг байх;
- 3.1.7. Комисс нэмэлт шаардлага тавьж, материал шаардаж болох бөгөөд үүнийг комиссын гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

3.2. Уралдаант шалгаруулалтад оролцох компани дараах материалыг Хороонд битүүмжлэн ирүүлнэ:

- 3.2.1. уралдаант шалгаруулалтад оролцох болсон шалтгаан, зорилго;
- 3.2.2. харилцагчдыг шилжүүлэн авснаар үүсэх үйл ажиллагааны үр ашгийн тооцоо, бизнес төлөвлөгөөнд оруулах өөрчлөлтийн төсөл;
- 3.2.3. шинээр байгуулах салбарт ажиллах мэргэжилтний талаарх мэдээлэл;
- 3.2.4. шилжүүлж авах харилцагчдад үйлчлэх салбарын ажлын байрыг хэрхэн шийдвэрлэх талаарх танилцуулга;
- 3.2.5. харилцагчдад хүргэх үйлчилгээг хэрхэн шуурхай болгож, сайжруулах саналтөлөвлөгөө;
- 3.2.6. салбарын үйл ажиллагааны дотоод журам, салбарын үйл ажиллагаанд хяналт тавих журмуудын төсөл;
- 3.2.7. тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон компаниас харилцагчдад учруулсан хохирлыг хариуцах эсэх, хэрэв хариуцвал ямар хэмжээгээр хариуцах /хариуцаж ажиллах компанийг давуу тал гэж үзнэ/;

3.3. Уралдаант шалгаруулалтад оролцох эрх бүхий компани энэ Журмын 3.3-т заасан материалыг уралдаант шалгаруулалт зарлагдсанаас хойш ажлын 20 хоногт багтаан Хороонд ирүүлнэ. Уралдаант шалгаруулалтын зарлалд материал хүлээж авах сүүлчийн хугацааг мэдээлнэ.

3.4. Энэ журмын 3.3-т заасан хугацаанд ямар нэг брокер, дилерийн компаниас материалаа ирүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон брокер дилерийн компанийн харилцагчдыг шилжүүлэх асуудлыг Хороо тусгай зөвшөөрөл бүхий, аль тохиромжтой, шаардлага хангахуйц брокер, дилерийн компанитай тохиролцож шийдвэрлэх арга эхэмжээ авна.

3.5. Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон компанийн харилцагчийн зөвшөөрөлгүйгээр тэдний хувьцааг худалдсан, мөнгө хөрөнгийг ашигласан хууль бус үйлдэлтэй холбоотой асуудлыг тухайн харилцагчийг шилжүүлэн авсан компани хариуцах саналаа энэ Журмын 3.3.1-д зааснаар ирүүлэгүй бол

хариуцахгүй. Дээрх байдлаар үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрх нь зөрчигдсөн харилцагч эрхээ сэргээлгэж, гэм хороо арилгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандахад харилцагчийг шилжүүлэн авсан компани шаардлагатай, өөрт байгаа мэдээллээр хангах үүрэгтэй.

### **Дөрөв. Бусад**

4.1.Тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон компанийн хэлцлийн жагсаалтыг үндэслэн дараах баримтыг “Монголын хөрөнгийн бирж” ХК хүлээж авна:

- 4.1.1. захиалгын гэрээ, гэрээ дүгнэсэн акт;
- 4.1.2. харилцагчийн бүртгэл;
- 4.1.3. дилерийн даалгавар;
- 4.1.4. баталгаажуулсан ХОЭБ-ийн үлдэгдэл;
- 4.1.5. сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан.

4.2.Баримт материалыг шилжүүлэх ажиллагаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК хяналт тавина.

4.3.Энэхүү журмын холбогдох заалтыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай болон холбогдох бусад хуульд заасан журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----000-----